



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Минжит булганы буян” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ХОА-2026/016/НА-СТА-ОНӨҮГ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn
Ховд хот	Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn
2026 он	Аудитор: Д.Нямгарав Утас: 99478813 Цахим хаяг: nyamgaravd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан .....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	8
3.1 Төлбөрийн акт .....	8
3.2 Зөвлөмж .....	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	9
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл .....	12

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/Факс: (976)-7043-3061  
Email: khovd@audit.gov.mn

2026.03.15 № 248

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“МИНЖИТ БУЛГАНЫ БУЯН” ОНӨААТҮГ-ЫН  
ДАРГА Б.БААСАНЖАВ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Булган сумын “Минжит булганы буян” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр “Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл” хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.5, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэхь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- 2025 онд бэлнээр 1.8 сая төгрөгийг үндсэн баримтгүйгээр зарцуулсан,
- Ховд аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансруу 2.3 сая төгрөгийг шилжүүлсэн. 2023 онд Булган сумын сум дундын шүүхийн 154/ШШ2023/00164 тоот шийдвэрээр төлбөр авагч Мандал даатгал ХХК-д олгохоор шийдвэрлэснийг 2025 онд төсвөөс төлсөн, авлагад бүртгээгүй,

8426050599  
А4 Албан тоот

- Хувь хүний орлогын албан татварын тайланд цалин хөлс түүнтэй адилтгах орлого 2.0 сая төгрөгийг тайлагнаагүй орхигдуулсан,
- Нийгмийн даатгалын тайлангийн үлдэгдлийг 1.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,
- Үндсэн баримтгүйгээр тайлант үеийн үр дүнг найдваргүй авлагын алдагдлын 15.5 сая төгрөгөөр бууруулсан,
- Булган сумын Засаг даргын тамгын газраас үлдэх өртөггүй 35.0 сая төгрөгийн Ковш авто машиныг балансаас балансад шилжүүлснийг орлогод авч данс бүртгэлд тусгаагүй,
- 2025 онд худалдан авч 51.2 сая төгрөгийн бараа материалыг орлогод авч данс бүртгэлд тусгаахаас 37.7 сая төгрөгийг данс бүртгэлд тусган орлогод авч 13.5 сая төгрөгийг орлогод аваагүй,
- Тус байгууллагад 2025 оны 8 дугаар сараас тухайн сумын цэвэр бохир усны үйл ажиллагаа нэгдэснээс хойш айл өрх, албан байгууллагаас хураах цэвэр бохир усны үнэ тарифыг тогтоогоогүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд аймгийн ИТХ-ын шийдвэрээр сумын Засаг даргын тамгын газраас 134.3 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг шилжүүлэн авсан, сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 106.1 сая төгрөгийн засвар үйлчилгээ хийж гүйцэтгэсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 33.9 сая төгрөг болж өссөн нь хувь хүний орлогын албан татвар 4.1 мянган төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 29.8 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр үүссэн өр төлбөр, мөн хувь хүмүүсээс авах авлага 1.5 сая төгрөг, бусад зардлын тооцооны авлага 52.6 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

2025 онд өөрийн орлогоор сумын ногоон байгууламжийг сэргээн засварласан, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2 удаа нохой устгал, Цагаан хаалга болон гэрэлтүүлгийн засвар үйлчилгээ, “Хог” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилласан.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>644,890.28</b>	<b>5,770,305.21</b>
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	644,890.28	5,770,305.21
31213	Арилжааны банк дахь харилцах	644,890.28	5,770,305.21
33	<b>АВЛАГА</b>	<b>45,056,600.00</b>	<b>99,006,400.00</b>
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	157,500.00	
335	Бусад авлага	44,899,100.00	99,006,400.00
3351	Байгууллагаас авах авлага	44,899,100.00	97,506,400.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага		1,500,000.00
34	<b>УРЬДЧИЛГАА</b>		<b>19,500,000.00</b>
346	Урьдчилж гарсан зардал		19,500,000.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>1,564,900.00</b>	<b>1,383,000.00</b>
354	Хангамжийн материал	1,564,900.00	1,383,000.00
3542	Аж ахуйн материал	576,900.00	395,000.00
3543	Сэлбэг хэрэгсэл	900,000.00	900,000.00
3547	Бусад хангамжийн материал	88,000.00	88,000.00
<b>I</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>47,266,390.28</b>	<b>125,659,705.21</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>75,239,166.69</b>	<b>207,904,926.04</b>
392	Биет хөрөнгө	75,239,166.69	207,904,926.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	76,800,000.00	295,968,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,560,833.31	-88,063,573.96
<b>II</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>75,239,166.69</b>	<b>207,904,926.04</b>
<b>III</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>122,505,556.97</b>	<b>333,564,631.25</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>33,943,881.99</b>
413	Өглөг		33,943,881.99
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		4,102,070.58
4136	Бусад өглөг		29,841,811.41
41361	Байгууллагад төлөх өглөг		29,841,811.41
<b>IV</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>33,943,881.99</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	122,505,556.97	299,620,749.26
512	Хуримтлагдсан үр дүн	122,505,556.97	299,620,749.26
5121	Өмнөх үеийн үр дүн	122,505,556.97	122,505,556.97
5122	Тайлант үеийн үр дүн		177,115,192.29
<b>V</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>122,505,556.97</b>	<b>299,620,749.26</b>
<b>VI</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>122,505,556.97</b>	<b>333,564,631.25</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан (төгрөгөөр)

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>121,153,000.00</b>	<b>106,115,400.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	121,153,000.00	106,115,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	121,153,000.00	106,115,400.00
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>208,661,700.00</b>	<b>454,954,809.68</b>
120	Нийтлэг татварын бус орлого	208,661,700.00	454,954,809.68
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	148,861,700.00	439,494,258.68
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		257,707,024.44
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	148,861,700.00	47,487,234.24
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		134,300,000.00
120009	Бусад орлого		500,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	59,800,000.00	14,960,551.00
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>329,814,700.00</b>	<b>561,070,209.68</b>

**“Минжит булганы буян” ОНӨААТҮГ 2025 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын хураангуй тайлан**

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>234,142,957.69</b>	<b>383,955,017.39</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>234,142,957.69</b>	<b>383,955,017.39</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	142,768,045.38	153,923,230.01
210101	Үндсэн цалин	142,768,045.38	153,923,230.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,734,042.00	44,991,866.00
210201	Тэтгэврийн даатгал	36,734,042.00	44,991,866.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,941,213.00	20,667,723.96
210301	Гэрэл, цахилгаан	6,941,213.00	20,667,723.96
2104	Хангамж, бараа материалын зардал	19,806,036.00	65,192,280.00
210401	Бичиг хэрэг	88,500.00	538,500.00
210402	Тээвэр, шатахуун	16,608,174.00	29,321,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	444,762.00	
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,664,600.00	35,332,380.00
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		8,331,280.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		8,331,280.00
2107	Томилолт, зочны зардал	200,000.00	1,530,000.00
210702	Дотоод албан томилолт	200,000.00	1,530,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,627,858.00	17,407,220.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		11,192,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		5,874,820.30
210804	Тээврийн хэрэгслийн татвар		232,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		99,000.00
210807	Газрын төлбөр	2,621,758.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,100.00	8,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,065,763.31	71,911,417.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,504,930.00	55,316,625.47
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,560,833.31	16,594,791.65
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>234,142,957.69</b>	<b>383,955,017.39</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>95,671,742.31</b>	<b>177,115,192.29</b>
<b>V</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>95,671,742.31</b>	<b>177,115,192.29</b>

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

(төгрөгөөр)

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад цэвэр хөрөнгө/өмч	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	122,505,556.97	122,505,556.97
7	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	92,692,178.05	92,692,178.05
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	122,505,556.97	122,505,556.97
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
17	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	177,115,192.29	177,115,192.29
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	299,620,749.26	299,620,749.26

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

(төгрөгөөр)

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>240,626,200.00</b>	<b>359,386,872.92</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	119,473,200.00	253,271,472.92
120	Нийтлэг татварын бус орлого	119,473,200.00	253,271,472.92
120002	Хүүгийн орлого		27,014.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	119,473,200.00	252,744,458.68
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		194,311,024.44
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	119,473,200.00	58,433,434.24
120009	Бусад орлого		500,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>121,153,000.00</b>	<b>106,115,400.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	121,153,000.00	106,115,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	121,153,000.00	106,115,400.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>242,519,309.72</b>	<b>354,234,443.75</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>242,519,309.72</b>	<b>354,234,443.75</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>242,519,309.72</b>	<b>354,234,443.75</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	144,140,330.72	144,233,024.13
210101	Үндсэн цалин	144,140,330.72	144,233,024.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,734,042.00	44,991,866.00
210201	Тэтгэврийн даатгал	36,734,042.00	44,991,866.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,941,213.00	20,667,723.96
210301	Гэрэл, цахилгаан	6,941,213.00	20,667,723.96
2104	Хангамж, бараа материалын зардал	17,141,436.00	56,813,980.00
210401	Бичиг хэрэг	88,500.00	556,500.00
210402	Тээвэр, шатахуун	16,608,174.00	28,057,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	444,762.00	99,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		28,101,080.00
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		11,512,280.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		9,752,280.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		1,760,000.00
2107	Томилолт, зочны зардал	200,000.00	1,530,000.00
210702	Дотоод албан томилолт	200,000.00	1,530,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,627,858.00	18,808,220.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		11,192,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		7,374,820.30
210804	Тээврийн хэрэгслийн татвар		232,400.00
210807	Газрын төлбөр	2,621,758.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,100.00	8,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,734,430.00	55,677,349.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,734,430.00	55,677,349.36
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>-1,893,109.72</b>	<b>5,152,429.17</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		

VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-1,893,109.72</b>	<b>5,152,429.17</b>
31	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>644,890.28</b>
31	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>5,770,305.21</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 91,148.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 70,010.6 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Үндсэн баримтгүйгээр тайлант үеийн үр дүнг найдваргүй авлагын алдагдлын 15,510.6 мянган төгрөгөөр бууруулсан,
- Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Булган сумын гудамж талбайн тохижилт, хашаа хайсны засвар үйлчилгээнд 19,500.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлсэн,
- Булган сумын Засаг даргын тамгын газраас үлдэх өртөггүй Ковш авто машиныг балансаас балансад шилжүүлснийг орлогод авч данс бүртгэлд тусгаагүй,

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй нийт 44,136.6 мянган төгрөгийн зөрчлөөс үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, авлагыг буруу буюу дутуу тайлагнасан нь материаллаг бус алдаа тул үлдэх 21,137.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс “их” байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 21,137.4 мянган төгрөгийн 7 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1,865.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 19,272.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгсөн.

#### 3.1 Төлбөрийн акт

##### 3.1.1 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын ажилтанд бэлнээр 365.0 мянган төгрөгийг үндсэн баримтгүйгээр олгосон, мөн “Минж тохоо” ХХК-ийн харилцах дансанд 1,500.0 мянган төгрөгийн гэрэлтүүлгийн хөлсний үнийг үндсэн баримтгүйгээр шилжүүлсэн, хийсэн ажил тодорхойгүй, нотлох баримтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална”, 13 дугаар зүйлийн 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

#### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 3.2.1 Нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой асуудал

<sup>1</sup> Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.

Илрүүлэлт: 2025 оны нийгмийн даатгалын тайланг 1,378.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлд заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн дагуу суутган тооцож, бүртгэлд үнэн зөв тусгах

### **3.2.2 Хувь хүний орлогын албан татвартай холбоотой асуудал**

Илрүүлэлт: 2025 оны хувь хүний орлогын албан татварын тайланг 2,070.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хувь хүний орлогын албан татварыг хуулийн дагуу суутган тооцож, бүртгэлд үнэн зөв тусгах

### **3.2.3 Бараа материалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: 2025 онд худалдан авч 51,237.5 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авч данс бүртгэлд тусгахаас 37,715.8 мянган төгрөгийг данс бүртгэлд тусган орлогод авч 13,521.7 мянган төгрөгийг орлогод аваагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын тайланг иж бүрэн гарган, сар улирлаар гаргаж ажиллах

### **3.2.4 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тус байгууллага нь Булган сумын сум дундын шүүхийн 154/ШШ2023/00164 тоот шийдвэрээр төлбөр авагч Мандал даатгал ХХК-д олгохоор шийдвэрлэснийг 2025 онд 2,301.5 мянган төгрөгийг төсвөөс төлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвөөс төлсөн зардлыг буруутай албан тушаалтнаас суутган төсвийг хохиролгүй болгох.

### **3.2.5 Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тус байгууллагад 2025 оны 8 дугаар сараас тухайн сумын цэвэр бохир усны үйл ажиллагаа нэгдсэнээс хойш айл өрх, албан байгууллагаас хураах цэвэр бохир усны үнэ тарифыг тогтоосон тогтоол, шийдвэргүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах

үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Айл өрх, албан байгууллагаас авах цэвэр, бохир усны үнэ тарифыг хуулийн хүрээнд эрх бүхий байгууллагаар тогтоолгон, шийдвэрийг мөрдөж ажиллах.

### **3.2.6 Зардалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тус байгууллага нь санхүүгийн гүйлгээг анхан шатны иж бүрдэл болоогүй баримтаар, мөн сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй хөтөлбөр арга хэмжээг гүйцэтгэл хангалтгүй, бараа материал, үндсэн хөрөнгийн данс бүртгэлийн орлого дутуу байгаа зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсөв шууд захирагчийн нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг хуулийн хүрээнд сайжруулах, иж бүрэн баримт бүрдлээр төсвийг зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-г заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн баримтгүйгээр тайлант үеийн үр дүнг найдваргүй авлагын алдагдлын 15,510,600 төгрөгөөр бууруулсан	1	15,510.6			1	15,510.6	1	15,510.6		
2025 онд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Булган сумын гудамж талбайн тохижилт, хашаа хайсны засвар үйлчилгээг Байтагцагаан бургаст ХХК-иар хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулж, 2025 оны 12 сарын 26-ний өдөр 19,500,000 төгрөгийг шилжүүлсэн	1	19,500.0	1	19,500.0			1	19,500.0		
Булган сумын Засаг даргын тамгын газраас үлдэх өртөггүй Ковш авто машиныг балансаас балансад шилжүүлснийг орлогод авч данс бүртгэлд тусгаагүй	1	35,000.0	1	35,000.0			1	35,000.0		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>70,010.6</b>	<b>2</b>	<b>54,500.0</b>	<b>1</b>	<b>15,510.6</b>	<b>3</b>	<b>70,010.6</b>		

##### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2025 оны 8 дугаар сарын 27-ны өдөр Минж тохоо ХХК-ийн харилцах дансанд 1,500,000 төгрөгийн гэрэлтүүлгийн хөлсний үнийг үндсэн баримтгүйгээр шилжүүлсэн, хийсэн ажил тодорхойгүй, нотлох баримтгүй, 2025 оны 7 дугаар сард бэлнээр 365,000 төгрөгийг үндсэн баримтгүйгээр зарцуулсан	1	1,865.0	1	1,865.0				
2025 оны нийгмийн даатгалын тайлангийн үлдэгдлийг 1,378,931 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	1,378.9					1	1,378.9
Хувь хүний орлогын албан татварын тайланд цалин хөлс түүнтэй адилтгах орлогыг тайлагнаагүй орхигдуулсан	1	2,070.2					1	2,070.2

“Минжит булганы буян” ОНӨААТҮГ 2025 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын хураангуй тайлан

2025 онд худалдан авч 51,237,570 төгрөгийн бараа материалыг орлогод авч данс бүртгэлд тусгахаас 37,715,830 төгрөгийг данс бүртгэлд тусган орлогод авч 13,521,740 төгрөгийг орлогод аваагүй	1	13,521.7					1	13,521.7
Тус байгууллагад 2025 оны 8 дугаар сараас тухайн сумын цэвэр бохир усны үйл ажиллагаа нэгдсэнээс хойш айл өрх, албан байгууллагаас хураах цэвэр бохир усны үнэ тарифыг тогтоогоогүй.	1	-					1	-
2025 оны 8 дугаар сарын 13-ний өдөр Ховд аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн данс руу 2,301,511 төгрөгийг шилжүүлсэн. 2023 онд Булган сумын сум дундын шүүхийн 154/ШШ2023/00164 тоот шийдвэрээр төлбөр авагч Мандал даатгал ХХК-д олгохоор шийдвэрлэснийг 2025 онд олгосон.	1	2,301.5					1	2,301.5
Тус байгууллага нь санхүүгийн гүйлгээг анхан шатны иж бүрдэл болоогүй баримтаар, мөн сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлсэн талаар ямар ч баримтгүй байгаа нь, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл дутуу, байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр цалин, урамшуулал олгосон зэрэг нь дотоод хяналтыг удирдлагын зүгээс тавих хяналт сул,	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>21,137.4</b>	<b>1</b>	<b>1,865.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>6</b>	<b>19,272.4</b>

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨҮГ	1	1				1		
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		